

АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. **Ховд аймаг дахь Төрийн Аудитын Газар нь ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ГЭРЭЭГЭЭР АУДИТ ХИЙХ ХАРААТ БУС АУДИТЫН КОМПАНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ** тул аудитын үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг сонирхолоо илэрхийлэхийг урьж байна.

2. Энэхүү аудитын үйлчилгээ нь Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5–д заасны дагуу Төсвийн захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх шаардлагын дагуу зарлагдаж байгаа болно. Аудитын үйлчилгээний гэрээний нийт хугацаа нь 2018 оны 12 сарын 1-нээс 2019 оны 6 сарын 20 хүртэл үргэлжлэх болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй аудитын хуулийн этгээд нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээлэл болон холбогдох бичиг баримтын баталгаат хуулбарыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх ба эдгээр нь Хураангуй жагсаалт бэлтгэх үндэслэл болно. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор аудитын хуулийн этгээдүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ, аудит хийх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тухайн жилд аудит хийх хуулийн цаглабар хугацаатай нийцсэн байх;
2. Аудитын компани нь хариуцлагын даатгалтай байх;
3. Аудитын компанийн захирал нь мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй байх;
4. Аудитын компани нь 2-оос доошгүй мэргэшсэн нягтлан бодогчтой байх;
5. Аудитын компанийн захирал болон мэргэшсэн нягтлан бодогчид нь мэргэжлийн ёс зүйн алдаа гаргаагүй талаар Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (ММНБИ)-ийн тодорхойлолттой байх;
6. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн 21.1 дэх заалтыг зөрчөөгүй байх;
7. Төрийн аудитын байгууллагын захиалгаар сүүлийн 2 жилийн хугацаанд аудитын ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх, хэрэв ийм ажил гүйцэтгээгүй бол мөн хугацаанд улсын салбарт ижил төстэй ажил хийсэн туршлагатай байх.
8. Сангийн Яам болон бусад мэргэжлийн байгууллагаас хийгдсэн чанарын баталгаажуулалтын дүгнэлт.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2018 оны 10 сарын 15-ний 17.00 цаг хүртэл** хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар **2018 оны 10 сарын 16-ны өдрийн 17.00 цагаас өмнө** ирүүлнэ үү.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗДТГ 3 давхар 305 тоот,
70433061